

# Хууль яагаад гууль болов



[”Өдрийн сонин”](#)

2006/11/20 - № 284 (2418)

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын 2006 оны илтгэлд хуулийн байгууллага хүний эрхийг аймшигтайгаар зөрчиж байгаа тухай маш ноцтой баримтууд нийтлэгджээ. Энэ бол ганц цагдаа ч биш, ерөөс манай хууль хамгаалах байгууллага бүхэлдээ дампуурсны дохио болох учир хар багаас ажиллаж, залуу насаа зориулсан прокурорын байгууллага минь ингэхэд хаана нь юу хийж байгаа юм бол гэх зовнилын үүднээс энэ сэдвээр бодол санаагаа олон нийттэй хуваалцахаар шийдэв.

## Товч түүх сөхвөл ...

Прокурорын алба шүүхээс хамаагүй хожуу үүсчээ. Эртний Герег болон эртний Ромд аливаа хэргийн хохирогч нь нотлох баримтаа өөрөө цуглуулж, шүүхийн өмнө буруутныг өөрөө ялладаг байжээ. Христийн тооллын I-IV зууны үеийн Ромд эзэн хааны түшмэл эрүүгийн мөрдөн мөшгих ажиллагааг явуулдаг болжээ. Дундад зууны инквизацийн үед эрэн сурвалжлах, мөрдөн байцаах, өмгөөлөх, шүүн таслах чиг үүргийг бүгдийг нь нэг этгээд ганцаар хэрэгжүүлдэг байв. Харин XIII–XIV зуунд зоргоор авирлагч феодалууд, салан тусгаарлагчидтай тэмцэхийн тулд Францын ван IV Филипп 1302 онд анх прокурорыг бий болгосон түүхтэй.

“Прокурор” хэмээх нэр нь санаа тавих, халамжлах гэсэн утгатай “procurare” гэдэг латин үгнээс үүсэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, хуулийг гууль болгуулахгүйн төлөө санаа тавина гэсэн үг.

Манай улсын хувьд 1930 онд Улсын 6 дугаар их хурал “прокурор” хэмээх хууль сахиулагчийг бий болгох шийдвэр гаргаснаар Монголд прокурорын байгууллага үүссэн гэж үздэг. Тэр үед Улсын Ерөнхий прокурорыг Шүүх яамны дэд сайд хавсардаг, харьяа прокурорууд нь аймгийн шүүх таслах газарт байнга сууж ажилладаг (“шүүхийн прокурор” гэдэг) байсан нь барууны орны жишигтэй нэлээд төсөөтэй байжээ. Харин 1940 оны Үндсэн хуулиас хойш Зөвлөлт маягийн загварт орж 1992 оны шинэ Үндсэн хуулийг хүртэл явж ирсэн юм.

Улсын Ерөнхий прокуророор миний ажилласан хугацаа бол манай улс орны түүхэн хөгжлийн огцом эргэлтийн нэн ээдрээтэй цаг үе байлаа. Халагдаж буй нийгмийн үед бүрэлдэн тогтсон бараг бүх зүйлийг бүхэлд нь хавтгайруулан үгүйсгэх үзэл нийгмийн сэтгэхүйд давамгайлж байсны дотор өмнөх нийгмийн төрийн тогтолцооны чухал хэрэглүүр болж байсан прокурорын байгууллагыг шинэчлэн сайжруулья гэхээс илүү түүнийг болж өгвөл халж үгүй хийх, үгүйдээ гэхэд эрх хэмжээг нь ёс төдий болтол хязгаарлах гэсэн туйлшрал хүмүүсийн дунд, ялангуяа хуулийн бусад байгууллага, хуульчдын зүгээс хүчтэй түрхрэн давалгаалж байв. Энэ хандлага Монгол Улсын шинэ Үндсэн хууль болон Прокурорын байгууллагын тухай хууль (1993 онд) батлагдан гарах хүртэл эрчтэй үргэлжилж билээ. Зарим нь Англи гэх мэт улсад прокурор биш, барристер, солиситор гэж байдгийг хальт мөлт дуулснаа иш үндэс болгон “өндөр хөгжилтэй барууны орнуудад прокурор гэж байдаггүй юм, тиймээс энэ байгууллагыг бүр татан буулгая” гэсэн санал ч гаргаж байв.

## Прокурорын байгууллагын шинэтгэлийн үйл явц

Улсын Ерөнхий прокурорын өндөр албан тушаалыг хэн олон жил хашсанаар нь биш, харин юу амжуулсан, юу үлдээснээр нь үе үеийн Ерөнхий прокуроруудыг үнэлэн дурсдаг. Жишээ нь, Ж.Авхиа гуайг прокурорын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд хамгийн их зүйл бүтээсэн гэж үнэлдэг. Миний хувьд байшин барилга, унаа машин, тавилга төхөөрөмж хөөцөлдөх зорилго тавиагүй, тэр үеийн төр засагт тийм боломж ч байгаагүй. Харин төрийн тогтолцоонд прокурорын байгууллагын эзлэх ёстой жинхэнэ байр суурийг нь олж тогтоох гарааны эхлэлийг шинэ Үндсэн хуульд зөв томъёолох

явдал гол зорилт байлаа. Энэ бол аж ахуйн ажил биш, оюуны хөдөлмөр байсан. Энэ ажлыг манай ажилтнууд болон зорилго нэгтнүүд хамтарч бүтээсэн. Үүнд ялангуяа Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч М.Одонхүү, прокурор Д.Баярсайхан, Г.Баясгалан (одоо Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга) нар идэвх чармайлттай ажилласныг тэмдэглүүштэй.

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд заасан прокурорын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх хэмжээ нь тухайн үеийн нийгмийн тогтолцоондоо тохирч байсан. Үйлдвэрлэлийн бүх хэрэгсэл төрийн өмчид байсан тэр үед прокурор өмчлөгчийн нүд, чих болж бүхнийг хамарсан ерөнхий дээд хяналт тавих үүрэгтэй байв. Ер нь аливаа нийгэмд өмчийн харилцаа бусад бүх харилцааны эх суурь нь болдог. Тиймээс хуулийн биелэлтийг хянах прокурорын байгууллагын үндсэн зорилго нь эцсийн дүндээ өмчийн эзний эрх ашгийг хамгаалахад л төвлөрч байсан юм. Төл бойжуулалт, төлөвлөгөөний биелэлт, өр барагдуулалт гээд прокурор оролцохгүй юм байдаггүй байв. Гэтэл 1992 оны шинэ Үндсэн хуулиар төрийн өмчийн дагнасан ноёрхолыг халж, улс орны эдийн засагт хувийн сектор давамгайлах чиг хандлагатай болсон учир прокурорын ерөнхий хяналт хуучин хэвээр үргэлжлэх эрх зүйн үндэс суурьгүй болсон. Жишээ нь, хувьчлагдсан үйлдвэрт төрийн нэрийн өмнөөс прокурор очоод юуг нь хянах билээ? Тэнд төрийн өмчөөс үүдэлтэй төрийн ашиг сонирхол үндсэндээ байхгүй шүү дээ. Хувийн компанийн өмчийн асуудалд төр хөндлөнгөөс оролцдог ганц шижим нь албан татвар байдаг. Тэр нь татварын албаны хийх ажил.

Төрөөс стандарт тогтоож түүний биелэлтийг хянаж байх ёстой. Энэ утгаар бол төрөл бүрийн мэргэжлийн хяналт байх нь зүйн хэрэг. Гэхдээ энэ нь хуулийн биелэлтийн биш, техникийн хяналт юм. Энэ бол прокурорын үүрэг биш. Прокурор гэж хэн билээ? Зөвхөн хуульч. Түүнээс инженер, санхүүч, эмч, агрономч биш. Хэн ч байлаа гэсэн мэргэжлийнхээ ажлыг л хийх ёстой. Гэтэл тэр үеийн прокурор бүх салбарын мэргэжлийн хяналтын ажлыг бүгдийг ганцаар хийх гэж оролддог байж дээ. БНМАУ-ын Ардын Их Хурал шинэ Үндсэн хуулийг хэлэлцэх явцад прокурорын ерөнхий хяналтыг яах вэ гэсэн депутатуудын асуултад улс ардын аж ахуйн салбарын хяналт шалгалтыг тухайн салбарын мэргэжлийн байцаагч нар хариуцах ёстой гэж би хариулж байснаа санаж байна. Тэр нь одоогийн Мэргэжлийн хяналтын алба болжээ.

Харин төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль биелүүлж буй байдалд прокурор хүний эрх, нийтийн ашиг сонирхолыг хамгаалах үүднээс хяналт (наад зах нь шилжилтийн үед) тавих ёстой гэж бид үзэж байсан. Одоогийн өндөрлөгөөс харахад энэ нь захиргааны хэргийн шүүхийн харьяалах асуудал боловч 1990-ээд оны турш ийм эрх, үүргийг прокурорт хариуцуулсан бол нэг их гай болохгүй л байсан боловч уу. Захиргааны хэргийн шүүх байгуулагдаад эдүгээ 2 жил болж байгаа боловч иргэний эрхийг зөрчсөн захиргааны байгууллагын хууль бус ажиллагааг бүрэн хамарч чадахгүй байгаа нөхцөлд захиргааны хууль бус актыг прокурор өөрөө шууд хүчингүй болгохгүй ч гэсэн шүүхийн өмнөх шатанд зөрчлийг засуулахаар шаарддаг эрхтэй байж болох л байж.

Үндсэн хуулийн болоод Прокурорын байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулан хэлэлцэх шатанд бид прокурорын байгууллагын үндсэн гол чиг үүрэг нь эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа (уголовное преследование) байх ёстой гэсэн концепцийг баримталж байсан. Мөрдөн шалгах = эрүүгийн хэрэг үүсгэх+мөрдөн байцаалтыг удирдан хянах+яллагдагчаар татах (ял сонсгох)+ялын дүгнэлт үйлдэх+шүүхэд яллах (яллагааг дэмжих)+ял эдлэлтийг хянах гэсэн хоорондоо салшгүй холбоотой, нэг нь нөгөөгөөс урган гардаг, нэгдмэл нэг эхлэл, төгсгөлтэй цогц үйл ажиллагаа хэмээн томъёолж байлаа. Үүнээс үүдээд прокурор эрүүгийн гэмт хэргийг шалгаж тогтоох ажлын хүрээнд мөрдөн байцаалтын ямар ч ажиллагааг шаардлагатай үед өөрөө биечлэн хийж магадлан шалгах эрхтэй байх ёстой гэж бид үзэж байсан юм. Тэгэхдээ мөрдөн байцаалтыг прокурор үндсэн ажлын хувиар биш, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон хэрэглэх учиртай. Прокурор өөрийн мөрдөн байцаах ажилд өөрөө хяналт тавих нь ерөөс аливаа хяналтын ажлын үндсэн зарчим (өөрөө өөрийгөө хянахгүй)-д нийцэхгүй нь БНМАУ-ын прокурорын байгууллагын өмнөх жилүүдийн туршлагаар нэгэнт нотлогдсон учир 1991 онд Улсын Бага Хурлын шийдвэрээр прокурорын байгууллагын аппаратын бүтцээс мөрдөн байцаах албыг тусгаарлан салгаж, цагдаагийн байгууллагад шилжүүлсэн юм.

Шинэ цагийн прокурорын байгууллагын чиг төлвийг тодорхойлсон Үндсэн хуулийн үзэл санааг цаашид гуйвалтгүй зөв хэрэгжүүлэн төлөвшүүлэх явдал Прокурорын байгууллагын тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх гэх мэт хуулиудыг хэр зөв хийхээс ихээхэн шалтгаалах байлаа. Гэтэл Прокурорын

байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орсон хэсэг нөхдүүд УИХ-ын хууль зарим гишүүдийн дэмжлэгтэйгээр “прокурор зөвхөн хөндлөнгөөс идэвхгүй ажиглаад сууж байх ёстой” гэх мэтээр прокурорын мөрдөн шалгах чиг үүргийн тухай концепцийг гуйвуулаад зогсоогүй 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх (ЭБШ) хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр прокурорын байгууллагын эрх хэмжээг улам бүр танаж хассаар эрүүгийн мөрдөн шалгах үндсэн бүрэн эрхийн чухал хэсгүүдийг цагдаагийн байгууллагад төвлөрүүлсэн байсан. Жишээлбэл, гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг прокурор хүлээн аваад өөрөө урьдчилан шалгаж магадлах эрхгүй, шууд л цагдаа руу шилжүүлдэг дамжуулагч төдий болсон байв. Прокурорын эрх, үүргийг ийнхүү хумин боогдуулснаар төрийн тогтолцоонд албадлагын хэрэгсэл болдог цагдаагийн болон адилтгах бусад байгууллагын үйл ажиллагаанд хууль сахиулах хяналтын ач холбогдол, үр нөлөөг сулруулж, улмаар хууль хэрэглэх нарийн мэргэжлийн ажлыг “тогооч авгай ч төр барьж болдог” хэмээх ойлголтоороо бүдүүлэгжүүлсэн. Үүний уршгаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд юуны түрүүнд хууль ёсыг удирдлага болгох мэргэжлийн сэтгэлгээ, хүмүүжил суларч эхэлсэн. Прокурорын хяналт ч хайнга хөндий оршоор идэвхгүй байдалдаа дасч, зэврэх өнгө аястай болж ирсэн. М.Алтанхуягийг Ерөнхий прокурор болсны дараа 2002 онд батлагдсан ЭБШ хуулиар прокурорын эрх хэмжээ өмнөхөөс өргөжсөн боловч мөрдөн шалгах чиг үүргийг дээр томъёолсон утгаар нь бүрэлдүүлж бас л чадсангүй. Гэвч нэг амьсгаагаар шийдэх боломжгүйд хүргэсэн объектив, субъектив шалтгаан байсан л биз. Харин энэ дашрамд тэмдэглэхэд, хууль хамгаалах байгууллагуудын хэрэглэдэг гол хуулиудыг 2002 онд шинэчлэн гаргахдаа өмнөхөөс бүр дордуулсан нь харамсалтай: Эрүүгийн болон ЭБШ хууль нь репрессив, Иргэний хууль нь хууль гэхэд ч хэцүү холион бантан, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль нь Үндсэн хуулиар тунхагласан давж заалдах эрхийг хязгаарласан гэх мэт. Муу хуулийн уршиг барагдашгүй, бүхэл бүтэн системийг сүйрүүлж чадаж байна! Компьютераар бол вирус л гэсэн үг. Хуулийг олуулаа хийснээр сайн болдоггүй, ганц нэг ч гэсэн ухаантай, мэдлэгтэй хүн хийвэл хамаагүй дээр. “Наполеоны хууль” гэж алдаршсан Францын 1804 оны Иргэний хуулийг 4 хуульч, эрдэмтэн (Порталис, Троншэ, Биго-де-Преаменэ, Маллевиля) зохиосон нь одоо хүртэл хүчин төгөлдөр үйлчлээд зогсохгүй эх газрын эрх зүйн системийн эх загвар болсоор байна. Гэтэл манай төр мэдэхгүй чадахгүй атлаа түүнийгээ мэддэггүй нөхдөөр л хууль хийлгээд байх юм.

### **Одоогийн байдлыг цэгнэвэл**

Эрх мэдэл их байх тусам алдах, эндэх, эвдрэх магадлал өндөр байдаг. 2002 оны ЭБШ хуулиар эрх хэмжээ нь өргөжсөний дараа прокурорууд хууль бус авирлах нь ихэслээ гэсэн шүүмжлэл сонсдох болов. Ажиглаад байвал оргүй биш бололтой. Жишээлбэл, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг зөвхөн прокурор л гаргах эрхтэй болсныг урвуугаар хэрэглэдэг гэнэ. Үүнээс бүр аюултай нь гэмгүй хүнийг хилс хэрэгт шийтгэх, хууль бусаар хорьж цагдах явдал улам бүр гаарч байна. ЭБШ хуулийн 58 дугаар зүйлд “хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол баривчилна” гэж заасан нь хүний эрх, эрх чөлөөг хамгийн ноцтойгоор зөрчих боломж олгож байна. Одоогийн Эрүүгийн хуулиар 102 зүйл ангид заасан гэмт хэргийг хүнд, онц хүнд гэдэг ангилалд хамааруулсан юм гэнэ. Тэгэхээр эдгээр хэргийн аль нэгэнд сэрдэгдсэн хэн ч гэсэн саадгүй баривчлагдах боломж нь нээлттэй. Хэрэгт сэрдэнэ гэдэг нь тухайн мөрдөн байцаагчийн субъектив ойлголт, хийсвэр дүгнэлт, хардалт байх нь олонтой. Учир нь: эрүүгийн хэрэг анх үүсгэх үед гэмт хэргийн тухай мэдээ нь шалгагдаж тогтоогдоогүй гол төлөв хэн нэгний гомдол, мэдээлэл, шүүмжлэл, атаархал, матаас (заримдаа гүтгэлэг) төдий зүйл байдаг учир эцэстээ хүнд ноцтой гэмт хэрэг болох эсэхийг урьдаас лавтай тодорхойлох боломж байдаггүй. Ийм үед хүнд хэрэг үү, хөнгөн хэрэг үү, ерөөс хэрэг мөн үү, биш үү гэдэг нь мөрдөн байцаагчийн бараг үзэмжийн асуудал болох нь ойлгомжтой. Одоогийн ЭБШ хуулийг репрессив гэж хэлээд байгаагийн зөвхөн ганц жишээ нь энэ. Нэгэнт ийм буруу хуультай нөхцөлд прокурор “... хангалттай баримт байгаа” эсэхийг л хатуу чанд хянах ёстой. Гэтэл дөрлүүлсэн үхэр шиг цагдаагийн амыг дагаж, “гүйцэтгэх ажлын мэдээгээр бол аймаар хэрэг гэнэ лээ” гээд барьж хорихыг дэмжээд суугаа нь өөрөө албаны гэмт хэрэг мөн. Ингэснээр цагдаагийн гэм бурууг прокурор өөр дээрээ шилжүүлэн авч буй хэрэг. Гүйцэтгэх ажлын ямар ч ноцтой мэдээ (мөрдөн байцаагчийн аман танилцуулга) баримтжаагүй л бол юу ч биш, түүнийг прокурор хэрхэвч дагаж болдоггүй юм.

Ерөөс юм л бол хорино цагдана гэж сүрдүүлдэг, хорих баривчлах явдлыг хэрэг хүлээлгэдэг үндсэн арга болгожээ! 1937 оны үеийн харанхуй бүдүүлэг байцаагч нарын арга барил ийм байсан гэдэг. Хэрэг мөрдөж илрүүлнэ гэдэг логик сэтгэлгээ шаардсан оюуны хөдөлмөр байдаг учир төрөлхийн ухаан мулгуу, боловсрол муутай, дээр нь хүний мөсгүй этгээдийг мөрдөн байцаагч, прокурор гээд тавьчихаар

муйхарлах нь арга ч үгүй биз. Тэд хүнийг айлган сүрдүүлж байж л хэрэг хүлээлгэхгүй бол ухаан дутах учир хэрэг илрүүлж чадахгүй. Чааваас, мунхагуудын буруу юу байхав, гэднийг төрийн ийм чухал албанд томилсон дарга нар (төр)-ын буруу л даа. Одоо цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон учир хүнийг цагдан хорихоор цагдаа, прокуророос тавьсан саналд шүүгч туйлын болгоомжтой, хариуцлагатай хандах үүрэгтэй бөгөөд алдаа гарвал эцсийн хариуцлагыг шийдвэр гаргасны хувьд шүүгч л хүлээх болно. Ийм журам тогтоосноос хойш өнгөрсөн хугацааны практикийг харахад цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсноор хүний эрхийн хамгаалалт сайжрах өнгө аяс мэдрэгдэхгүй л байна. Харин ч заримдаа өмнөхөөс бүр дордоо юу гэлтэй. Үүний нэг шалтгаан нь хорьж цагдах тухай шийдвэр гаргахын тулд сэжигтэн, яллагдагч буюу түүний өмгөөлөгчийн тайлбарыг сонсохгүйгээр дан ганц прокурорын саналыг дагаж байгаатай холбоотой. Хилсээр баривчлагдаж хоригдсон хүмүүс одоо биш юм гэхэд хэдэн жилийн дараа гомдол нэхвэл чанга унана гэдгээ шүүгч нар мартаж болохгүй шүү!

Цагдаагийнхан хэн нэгэн албан тушаалтанд холбогдох маш том ноцтой хэрэг илрүүлээ гэж эхлээд сүржин зарладаг. Хэргийн талаарх анхны мэдээ ерөөс шалгагдаж нотлогдоогүй зүйл байдаг учир шумуулыг тэмээ мэтээр дүрсэлсэн ч байж мэднэ. Гэтэл шалгах явцад тэр нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, аж ахуйн зөрчил, маргаан төдий асуудал байх нь цөөнгүй. Нэгэнт анхнаас шуугиулчихсан учир мөрдөн байцаагч өөрөө хэрэгсэхгүй болгох зориг дутдаг. Тэгээд “уснаас хуурай гарах”-ын тулд прокуророор “могой бариулах” гэдэг. Прокурор нь бас хульчийж хууль бусаар холбогдуулсан хэргээс хүнийг салгаж өгдөггүй. Ингээд дунд нь гэмгүй хүн хохирно. Одоо бүр сүүлдээ улс төрийнхний захиалгаар хүнийг зохиомол хэрэгт холбогдуулан баривчлах, хорих зэргээр дарамталдаг болжээ. Прокурорт гомдол гаргахад “уг нь энэ хэрэг биш л дээ, гэхдээ дээрээс шахаад болохгүй байна” гэх ухааны юм ярьж суугаа нь хуулийн байгууллагын ажилд улс төрчид гүн хутгалдан орсныг гэрчилнэ. Гэхдээ эцсийн хариуцлагыг захиалагч биш, прокурор л хүлээнэ шүү!

Ерөөс гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй асуудалд хүнийг хүчээр холбогдуулсан байхад прокурорууд тэр чигээр нь шүүх үрүү явуулчихдаг болж. Шүүх нь дуулиантай хэргийг унтраасан гэж шүүмжлүүлэхээс айгаад шийтгэж ч мэднэ. Шүүх дээр хэрэг цагаадсан ч хариуцлага тооцдоггүй бололтой. Зүй нь тийм алдаа гаргасан прокурор эрүүгийн хариуцлагад татагдах ёстой. Одоо ч бүр цайжээ. Хилсээр нэг хүн шийтгэснээс хэрэг хийсэн гурван хүнд ял завшуулсан нь дээр гэдэг юм. Цаг төрийн байдал дандаа ийм байгаад байхгүй нь лавтай, шинэ цаг ирж л таарна. 1970-1980-аад оны үед хилсээр шийтгүүлсэн олон хүний хэрэг 1990-ээд оны эхээр цагаадсан шиг хэдэн жилийн дараа 2000-аад онд хэлмэгдсэн хүмүүсийн хэрэг гэж бас баахан хэрэг цагаатгах ажил гарах вий дээ. Тэгвэл хэлмэгдүүлэгч нар ч зүгээр өнгөрөхгүй байх шүү! Хэрэг хуучирдаггүй гэсэн монгол хэлц үг байдаг байхаа?

Жирийн иргэнийг хэлмэгдүүлэхдээ эрэмгий атлаа төрийн өндөр албан тушаалтнуудын авилгын тухай баримт сэлт бүхий мэдээлэлд болохоор нүд нь балай, чих нь дүлий. Тийм болохоор авилгач нар нь эрэмшин даварч, “намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ” гэгчээр бараг ил цагаандаа гарах нь холгүй. Гэмт хэргийн тухай ноцтой мэдээ баримт болгоны талаар хуулийн байгууллага ямар арга хэмжээ авсныг татвар төлөгч шаардаж мэдэх эрхтэй, цаадуул (тэжээврүүд) нь илтгэх үүрэгтэй. Ноцтой нэг ч гэсэн хэргийг шалгахгүй орхисон тохиолдолд хуулийн байгууллагын удирдлага нийтийн өмнө асуугдаж хариуцлага хүлээх ёстой! Социализмын үед ч тийм хатуу нэхэл байсан юм. Үүрэгт ажлаа хийхгүй байгаа нөхдийг хариуцдаг дээд байгууллага, албан тушаалтан нь юу харж сууна вэ? Эцсийн хариуцлагыг нь өмнөөс нь хүлээх юм уу? Логик нь тийм л байна шүү дээ. Тэмцэх ёстой нь амьд хүүр шиг болчихсон (болгочихсон) учир Авилгатай тэмцэх байгууллага шинээр бий болгож байгаа юм гэнэ. Тэр нь төрөлхийн сульдаатай бол яах вэ? Дахиад шинэ алба байгуулах уу? **Хариуцлагын механизмаа ажиллуулахгүй бол юу ч байгуулаад нэмэргүй шүү дээ. Хариуцлагын тогтолцоо нийгэмд объектив оршдог боловч түүнийг төрийн дээд удирдлагын зүгээс зориуд орхигдуулбал уг механизм таг зогсдог.** Үлгэрлэвэл: жолооч нь машинаа асаах гэж оролдоо ч үгүй атлаа машин ажиллахгүй байна гэж зорчигчдыг хуурах, эсвэл та нар цугаараа түрвэл машин асна гэх мэтээр мэхлэхтэй адил. Түлхүүрийг нь хармаалчихсан жолоодогч хөдлөхгүй бол ямар ч шинэ төхөөрөмжөөр нэмж тоноглоод машин асахгүй нь ойлгомжтой. Эх нь булинггар бол адаг нь булинггар гэгчээр төрийн дээд албан тушаалтнууд бохир, шударга бус байвал авилгатай хийх тэмцэл амжилтад хүрэхгүй. Өөрөөр хэлбэл, авилга багасахгүй байвал төрийн дээдчүүд бузар юм байна гэж л ойлгох хэрэгтэй. Үнэхээр чин хүсэл байвал “мэдэхгүй бөгөөд чадахгүй хэмээх зүйлгүй” гэдэг биз дээ? Тэгэхээр хүсэхгүй л байна гэсэн үг. Ингэхэд манай том авилгач нар эх орноо “аалзны тор”-нд ийнхүү ороож хаясны төлөө дараа хэзээ нэг цагт хариуцлага тооцох болохоор гадагшаа дүрвэж гарна гэж бодож байгаа юм байх даа? Гадаад улс эрүүгийн гэмт

хэрэгтнийг орогнуулах эрх байдаггүй. Өөрийгөө биш юм гэхэд үр хүүхэд, ач гуч нараа боддоггүй юм уу? Эцэг, эхийн хэргийг үр хүүхдэд нь нялцаахгүй хуультай боловч ёс суртахууны хувьд дараа үеийнхэн тэднийг чинь нулимж чичлээд байвал яана? Гишгэх газаргүй, эх оронгүй болгоно шүү дээ!

Прокурорын байгууллага бол нэгдмэл төвлөрсөн удирдлагын зарчимтай: дээд шатны прокурорын заалтыг доод шатны прокурор заавал биелүүлэх үүрэгтэй ба дээд шатны прокурор нь өгсөн үүргийнхээ хариуцлагыг доош нь нялзаахгүй өөрөө хүлээдэг ёстой. Харин доод шатны прокурор өөрөө мэдэж буруу зүйл хийвэл хариуцлагаа өөрөө хүлээх нь мэдээж. Эцсийн дүндээ монголын прокурорууд бүгд Улсын Ерөнхий прокурорт захирагдах ба тэрээр бүх прокурорын төлөө хариуцлага хүлээх учиртай. Ингэж байж хууль ёсны талаар нэгдмэл нэг мөр ойлголт тогтдог. Тодорхой хэргийг хэрхэн яаж шийдвэрлэх тухайд ч дээд шатны прокурор заалт өгөх эрхтэй байдгаар шүүхээс ялгаатай. Хууль ёсны тухай асуудлаар шат шатны прокурорууд тус бүрдээ өөр өөр байр суурьтай, өөр өөрийнхөөрөө зүтгээд байвал прокурорын байгууллага биш болж хувирна. Ерөнхий прокурор бүгдийг нэгтгэн зангидаж, өөрийн байр суурийг хэлбэрэлтгүй тогтоох үүрэгтэй. Тэрээр доод шатны прокурорыг буруутгаад өөрөө зэмгүй гарна гэж байхгүй учир хариуцлага нь ер бусын хүнд хэцүү албан тушаал. Тийм ч учраас түүнийг сайд нараас ч онцлон үзээд байдаг хэрэг. Прокурорын хяналтын онолын ном зохиолд аливаа улсын төрд ганц л прокурор байдаг, тэр нь Улсын Ерөнхий прокурор ба бусад нь түүнд тусалдаг ажилтнууд төдий юм гэж бичсэн нь гагцхүү энэ субъект л системээ төлөөлж төрийн өмнө үүрэг хүлээдэг гэсэн санаа болов уу. Ийнхүү нуршихын учир нь манай прокурорын байгууллагад энэ зарчим сулрах төлөвтэй байгааг анхааруулах гэсэнд оршино.

Аливаа байгууллагын нэр хүнд ажиллагсаас шууд хамаардаг. “Нэг үхрийн эврээс мянган үхрийн эвэр доргино” гэгчээр нэг прокурор ёс бус авирлавал прокурорууд ингэдэг гэсэн үнэлгээ авах нь энүүхэнд. Прокурорууд бие биеэс болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас хууль бус зүйл гуйх, хувийн элдэв дутагдал гаргах зэргээс болоод өөрийгөө нээнтэгт оруулан албан ажлын зарчимч шаардлага тавих нэр нүүргүй болж, улмаар албаны сахилга сулран ажил цалгардах, асуудлыг хууль ёсны дагуу шийдэхгүй чирэгдүүлэн завхруулах явдал газар авах шинжтэй. Ялангуяа дарга нар нь доод ажилтныхаа өмнө ийм байдалд орохоор тэр байгууллага бүхэлдээ сульдаж, ажиллах чадваргүй хэвтрийн өвчтөн шиг болдог. Улмаар хууль бус авирлагч асман дарганцар, жижиг түшмэлүүд хэнд ч дийлдэхгүй дархлагдсан амьтад болох ба тийм юмнууд олширвол төр, нийгэмд заналтай. Дунд, доод шатны цагдаа болон прокурорын хууль бус үйлдэл, шийдвэрийн талаар гомдол гаргахад доошоо зарчимтай хатуу шаардлага тавьж, нугалаа завхралыг эрс шийдэмгий тас цохьдог прокурор, цагдаагийн дарга бараг үгүй болжээ. Дарга нарт нь гомдол гаргахад “Та нар манай доод хүмүүстэй сайн ажилла л даа” гэж зөвлөдөг гэнэ. Энэ ер нь юу гэсэн үг вэ? Энэ бүхэн чинь тэгэхээр дампуурлын шинж биш үү? Банкны эрх зүйд дампуурч байгаа банкныг аврах эцсийн арга болгож “бүтцийн өөрчлөлт хийх” гэдэг ойлголт байдаг. Зүйрлэвэл прокурорын байгууллагад ийм өөрчлөлт хийхээс аргагүйд хүрч магадгүй. Банкинд бол үүний тулд гаднаас Эрх хүлээн авагчийг томилдог шүү дээ. Ер нь гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагад үнэхээр үндсэн шинэчлэл хийе гэвэл одоогийн тогтолцоог нь өөрчилж, эрүүгийн тагнуулын албыг дотроо багтаасан Мөрдөн байцаах газрыг Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний бие даасан агентлаг болгож, хэв журмын болоод замын цагдаа гэх мэтийг орон нутгийн засаг захиргааны харьлалд шилжүүлэх хэрэгтэй. Мөрдөн байцаах ажлын процессийн удирдлагыг прокурор хэрэгжүүлэх ба Хууль зүйн сайд мөрдөн байцаах ажиллагаанд хушуу дүрэх хатуу хориотой, хэрэв энэ хориог зөрчвөл шууд огцрох шалтгаан болдог байхаар хуульчлах ёстой. Үйл ажиллагааны зарчмыг нь хуулиар зөв сайн тогтоож чадвал иймэрхүү схем байх боломж бий.

Монголын төр системээрээ хямралд оржээ гэлцдэг. Гэхдээ төрийг ийм байдалд үл бүтэх хүмүүс л оруулсан учир түүнээс гарах эсэх нь мөн л хүнээс хамаарах ёстой. Цаг хугацаа л эмчилнэ гээд хүлээгээд сууж боломгүй байна. Нийгэм, төр бүхэлдээ хямралтай байхад ганц нэг байгууллага, хувь хүн эрүүл үлдэх боломжгүй гэж дутагдлаа хаацайлах, сэтгэлээ хуурахыг явч зөвтгөж болохгүй, нийгмийн шизофренийн энэхүү булингарт урсгалын ёроолд нь живж үлдэлгүй, ядаж мандал дээр нь хөвөж явахыг хичээх нь чухал юм даа.